



НИЙСЛЭЛИЙН
ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 13 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

Хэвлэмэл хуудас хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоол, "Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар"-ын 7 дугаар зүйлийн 7.3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтын тооцоог 2019 оны жилийн эцсийн байдлаар гаргаж, байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Архив бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн /Ц.Дэлгэрмаа/-д үүрэг болгосугай.

2. Хавсралтад дурдсан хэвлэмэл хуудсыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Хэвлэмэл хуудсыг үргүй зарцуулахгүй байх, зарцуулалтын дагуу ашиглах, стандартын шаардлага хангасан баримт бичиг боловсруулж ажиллахыг нийт ажилтнуудад даалгасугай.


ДАРГА



Ш.НАРАНБААТАР

3140600014

Нийслэлийн Төр захиргааны авто баазын даргын 2020 оны 01 дүгээр сарын 13 ны өдрийн 1145 дүгээр тушаалын хавсралт



ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ХЭВЛЭМЭЛ ХУУДАС

2020 оны 01 дүгээр сарын 13

Улаанбаатар хот

Д/Д	Нэр төрөл	Хэвлэмэл хуудасны индекс	Хүчингүй болгосон шалтгаан	Тоо ширхэг
1	Тушаалын бланк	481-485, 293-294, 342-344, 403-405	Буруу бичсэн, хэвлэгчийн хор жигд бус, буруу принт өгөгдсөн	15
2	Албан бичиг А5	381-401	Буруу принт өгөгдсөн	20
3	Албан бичиг А4	120-125	Нэр буруу бичигдсэн, хэвлэгчийн хор жигд бус	5